


ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ



Ю.ОЮУНАА

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш,
ахлах дэслэгч

Товч агуулга: Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд тулгамдаж буй асуудлыг ШШГТухай /2017/ хуулийн шинэчлэлийн үр нөлөө, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал, шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын хэрэгцээ шаардлага, шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал зэрэгт шинжилгээ хийж дүгнэж үзсэн.

Abstract: The purpose of this study is to analyze on reform effectiveness of Law on Execution of Court Decision, bailiff work load, incentive needs and requirements, and security to determine ongoing issues of bailiff legal status.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал, урамшуулал, аюулгүй байдал

Key words: Bailiff work load, incentive, security

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга (2017) хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хурдан, шуурхай, үр дүнтэй, иргэд, олон нийтэд хүртээмжтэй байлгах, шийдвэр гүйцэтгэгчийн албандаа хандах сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ хэмээн тооцож байсан.

Гэвч хууль хэрэгжиж эхлээд 4 дэх жилийн нүүрийг үзэж байгаа хэдий ч шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй, иргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжгүй байсаар байгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сүүлийн жилүүдийн статистик мэдээнээс харж болно.

Тухайлбал 2018 оны жилийн эцсийн мэдээний үзүүлэлтээр гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 52.0 хувь, 2019 онд 51.7 хувь, 2020 онд 41.3 хувьтай¹ гарсан нь шүүхийн шийдвэрийн бодит биелэлт өмнөх жилүүдээс буурч,

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны жилийн эцсийн мэдээ, судалгаа (2018, 2019, 2020).

мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч, бусад этгээдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай болон шийдвэр гүйцэтгэгчийн харилцаа, ёс зүйтэй холбоотой 2018 онд 753, 2019 онд 1000 өргөдөл ирсэн байх бөгөөд зөвхөн нэг жилийн дотор 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Статистик мэдээний үзүүлэлтээс шүүхийн шийдвэр заавал биелэгддэг байх зарчим бодит байдал дээр хэрэгжихгүй, Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх хангагдахгүй байгаа шалтгаан нөхцлийг судалж тогтоон, шийдвэрлэх шаардлагатайг харуулсаар байна.

Шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль, эрх зүйн зохицуулалт, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн эрх зүйн ухамсар, соёл гэх мэт олон хүчин зүйл нөлөөтэй хэдий ч хамгийн гол нь шийдвэр гүйцэтгэгчийн хичээл зүтгэлээр шүүхийн шийдвэр биелэлээ олж хүний хөндөгдсөн эрхийг сэргээх үндэслэлийг бий болгодог.

Иймээс шийдвэр гүйцэтгэгч нэг бүрийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэхийн тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тэдний мэдлэг, ур чадвар, ажилдаа хандах хандлагад онцгой анхаарч тулгамдаж буй асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байх шаардлагатай юм.

Судлаач би төрийн хариуцлагатай, онцлог чиг үүрэгтэй албыг хашиж буй “Шийдвэр гүйцэтгэгч”-ийг албан үүргээ гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудлыг судалж үзэхийг зорьлоо.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх хариуцлагатай ч, амаргүй ажлыг улсын хэмжээнд 237 шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэж, тэдгээрийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүргийг 44 ахлах шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд алба хаагчдын 63.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байдгаараа онцлогтой.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх замаар хүний эрхийг хангах үйлсэд өөрсдийн ар гэрийн амьдралыг хойш тавин өргөсөн тангарагтаа үнэнч байж цаг хугацаа, орон зай, хүнд хэцүүг умартан зүтгэж буй тэднээр бахархахгүй байхыг аргагүй ээ.

Яг энэ мөчид БНСУ-ын дээд шүүхийн шүүгчийн хэлсэн үг санаанд орж байна.

Тэрээр хэлэхдээ: “Тэнгэрт үнэлэгдэх цэцэн мэргэн шүүхийн шийдвэр байлаа ч гүйцэтгэхгүй л бол хэнд ч хэрэггүй цаастай адил” хэмээн зүйрлэсэн нь шүүхийн шийдвэрийн амь нь шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын үр шимд оршдогийг илэрхийлсэн үг байлаа.

Нийгэм эдийн засгийн харилцаа өргөжин тэлэхийн хэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ тэлж, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүн, биелүүлэх шийдвэрийн төрөл нэмэгдэж байгаа өнөө үед шүүхийн шийдвэрийг шуурхай, үр дүнтэй гүйцэтгэх нь шийдвэр гүйцэтгэгчээс ихээхэн ур чадвар, хичээл зүтгэл, тэвчээр хатуужлыг шаардсаар байна.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь хууль, журмаар далайлган хийчихдэг ажил биш юм. Шүүхийн шийдвэрийн төрөл, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчид харилцан адилгүй байдгаас шалтгаалан тухайн гүйцэтгэх баримт бичигт хийгдэх ажил, хэрэглэх тактик нь өөр өөр байх ба шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авахаас хааж дуусгавар болгох хугацааны туршид үүссэн бэрхшээл бүрийг даван туулж ажлыг үр шимээ үздэгийг уг ажлыг хийж үзсэн, мэдэрсэн нэгэн л ойлгох юм.

Тухайлбал шийдвэр гүйцэтгэгч нь иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, эрүүгийн хэргийн хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийн шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ийнхүү ажиллахдаа өдөр тутамдаа төлбөр төлөгч, бусад этгээдийн хүч түрсэн эсэргүүцэл, төлбөрөөс зайлсхийсэн үйлдэлтэй тулгарах, тэдний зүгээс ирэх зөрчил, маргаантай нүүр тулах, байгалийн хүнд хэцүү цагт ч үүрэгт ажлаа гүйцэтгэх, цаашлаад аюул, осолд өртөх явдал ч нэлээдгүй гардаг байна.

Жишээ дурьдахад: 2019 онд Увс аймагт албан үүргээ гүйцэтгэж явсан шийдвэр гүйцэтгэгчдийн биед төлбөр төлөгч халдаж эрүүл мэндийг хохироож, шүүхээр ял шийтгүүлсэн бол, 2013 онд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт үүргээ гүйцэтгэж байсан шийдвэр гүйцэтгэгчийн амь насыг хохироосон ноцтой хэрэг ч гарсан байдаг.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч байсан хүндрэлтэй асуудлуудыг шийдсэн зохицуулалтуудыг хуульчилсан ч шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг сайжруулсан зохицуулалт төдийлөн тусгагдаагүй, харин ч өмнөх хуулийн хүрээнд үйлчилж байсан шийдвэр гүйцэтгэгчийн мөнгөн урамшууллыг үгүй болгож, цэргийн цол хэрэглэдэг болгосон байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын зарим шийдвэр гүйцэтгэгчид нартай хийсэн ярилцлагаар шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд тулгамдаж буй асуудал нь:

- ажлын ачаалал их,
- урамшууллын эрх зүйн зохицуулалтыг буцаан хуульчилах,
- өмнөх хуулийн хүрээнд энгийнээр ажилласан жилийг цэргийн болгох,
- шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд анхаарах шаардлагатай байгааг

тэд онцолсон юм.

Дээрх асуудлууд үүссэн шалтгаан, үр дагаварыг шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байранд зураг авалт хийх, санал асуулга авах, ярилцлага хийх, холбогдох

хуулийн зохицуулалт, статистик судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аргаар судалж үзлээ.

1. Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллын талаар:

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг нормативийг тогтоохдоо харьяалах нутаг дэвсгэрийг бүсчилсэн байдлаар тогтоож 1 дүгээр бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 180 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар, 2 дугаар бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 150 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар, 3 дугаар бүсэд хамаарах газар, нэгжийн 1 шийдвэр гүйцэтгэгч 120 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар тогтоосон байдаг².

Гэвч бодит байдал дээр шийдвэр гүйцэтгэгч бүрийн ажлын ачаалал нь харьяалах тойргийн газар нутгийн хүн амын төвлөрлөөс шалтгаалаад зарим тойрогт жишиг нормативт заасан тооноос их, бага зэргээр харилцан адилгүй байна.

Иймээс Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчийн ажлын нэг өдрийг сонгон ажлын байрны зураглал хийхэд дараах дүр зураг гарч байна.

1. Ажлын 7 хоногийн эхний өдөр ахлах шийдвэр гүйцэтгэгчээр батлуулсан төлөвлөгөөний дагуу төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хаягаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гүйцэтгэх баримт бичгийг ангилан бэлдэхэд 30 минут

2. Шийдвэр гүйцэтгэгчтэй уулзахаар ирсэн 3 төлбөр төлөгч, төлбөр авагч иргэнийг хүлээн авч уулзан санал хүсэлт, гомдлыг сонсон, тайлбар авч, мэдэгдэл гардуулахад 1 цаг 15 минут

3. Шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн яаралтай судалгааг гаргаж өгөхөд 1 цаг

4. Төлбөрийн дансанд төвлөрсөн мөнгийг төлбөр авагч нарт олгох 6 мэдэгдлийг бичиж, ахлах шийдвэр гүйцэтгэгч болон ахлах нягтлан бодогчоор хянуулж, гарын үсэг зуруулах /талуудын өр төлбөртэй эсэхийг бүртгэлийн ажилтнаас тодруулж тэмдэг дарж баталгаажуулах ажиллагаа хамаарна/-д 35 минут

5. Шүүхээс шинээр ирсэн 3 гүйцэтгэх баримт бичгийг хавтаслан нааж, төлбөр авагчтай байгуулсан зардлын гэрээг нягтлан бодогчоор шалгуулж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр батлуулах, иргэний болон эд хөрөнгийг тогтоохоор цахим сангаас лавлагаа авах, лавлагаагаар тогтоогдсон хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх албан бичгийг төлөвлөж, холбогдох газруудад хүргүүлэх,

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний нэгж байгууллагад алба хааж байгаа албан

хаагчдын ажлын жишиг норматив. <https://www.legalinfo.mn/law/details/7475>

тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй 5 төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн харилцах дансыг битүүмжилж, хасалт хийх тогтоолыг төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан, газрын даргаар батлуулж 13 арилжааны банкуудад цахимаар болон шуудангаар хүргүүлэх /бусад байгууллагуудад хүргүүлэх албан бичигт холбогдох баримт бичгийг хуулбарлах, тэмдэг дарж баталгаажуулах ажиллагааг гүйцэтгэдэг/ 2 цаг

6. Төлбөрөө бүрэн төлж барагдуулсан 1 иргэний харилцах данс болон тээврийн хэрэгслийн захиран зарцуулах эрхийг сэргээх, мөн төлбөрт гаргуулж болохгүй орлого буюу хүүхдийн мөнгөний данс сэргээлгэхээр хүсэлт гаргасан 1 иргэний харилцах дансыг сэргээх тогтоолыг төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан, газрын даргаар батлуулах/ бүртгэлийн ажилтнаас данс сэргээлгэх иргэнийг бусдад төлбөртэй эсэхийг шалгах ажиллагаа хамаарна/-д 30 минут

7. Төлбөр төлөгч, төлбөр авагч талууд харилцан эвлэрч, төлбөртөө тооцон хөрөнгө шилжүүлэх хүсэлт гаргасны дагуу 2 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст өмчлөх эрх шилжүүлэх албан бичгийг тус тус төлөвлөж, ахлах шийдвэр гүйцэтгэгч, дэд даргаар хянуулан, газрын даргаар гарын үсэг зуруулах /дагалдах баримт бичгийг хуулбарлан тэмдэг дарж баталгаажуулах ажиллагаа хамаарна/-д 45 минут

8. Хотын төв буюу орон сууцтай хороонд 1 албан байгууллагад яаралтай албан бичгийг хүргэж, төлбөр төлөгч 2 хуулийн этгээд, 2 иргэний оршин суугаа хаягаар очиж эд хөрөнгөнд үзлэг нэгжлэг хийх, үл хөдлөх эд хөрөнгө битүүмжлэх, мэдэгдэл гардуулах ажиллагаа явуулахад 3 цаг

9. Хотын зах буюу ажлын байрнаас 25-30 км зайд байрлах гэр хорооллын 2 төлбөр төлөгч иргэний оршин суугаа хаягаар очиж хураан авах, мэдэгдэл гардуулах ажиллагаа явуулахад 3 цаг /хаяг тодорхойгүйгээс хайж олоход хугацаа их ордог/

10. Тухайн өдрийн хийж гүйцэтгэсэн ажлыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид шалгуулах /хийсэн ажлаа цахим бүртгэлд оруулж, дэвтэрт бичиж тэмдэглэх, гүйцэтгэх баримт бичгийн баяжилт, товъёог хийх ажил хамаарна/-д 40 минут

11. Дараагийн өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гүйцэтгэх баримт бичгээ бэлдэх, шаардлагатай албан бичиг, лавлагааг төлөвлөх, гүйцэтгэх баримт бичгүүдээ эмхэлж цэгцлэх, товъёог бичих, холбогдох байгууллагуудаас ирсэн лавлагааг гүйцэтгэх баримт бичгийг нааж хавсаргахад 1 цаг 30 минут

Шийдвэр гүйцэтгэгч өдөр тутамдаа тогтмол хийдэг ажлуудын цагийг нэгтгэн дүгнэхэд 13 цаг 50 минут болж байгаа юм³.

³ Ю.Оюунаа, М.Хажидмаа. “Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалалд хийсэн судалгаа” (2020).

Зураг авалтанд багтсан ажлаас гадна төлбөр төлөгч, бусад этгээдийн хүч түрсэн эсэргүүцэл, төлбөрөөс зайлсхийсэн үйлдэлтэй тулгарч, ажлын байранд байнга сууж ажиллахаас илүү төлбөр төлөгчдийн араас хөөцөлдөх, төлбөр төлөгч, тэдний хөрөнгийн мэдээлэл, нотлох баримтыг цуглуулах, өөрийн гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд төлөөлөн оролцох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дуудсан цагт очиж тайлбар, мэдүүлэг өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх г.м. ажлыг хийж гүйцэтгэдэг байна.

2. *ШШГТухай /2017/ хуулийн шинэчлэлээс албан хаагчид хохирсон талаар:*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002/ хуулиар шийдвэр гүйцэтгэгчийг эрх зүйн дээд боловсролтой байхаар, уг хуулийн 9, 83 дугаар зүйлүүдэд “Шүүхийн шийдвэрийг бодитой гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчид гүйцэтгэсэн мөнгөн дүн, эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10.0 хувиар мөнгөн урамшуулал олгох, шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг уг төвлөрүүлсэн урамшуулаас санхүүжүүлэх”-ээр хуульчилж өгсөн⁴ нь эрх зүйн дээд боловсрол эзэмшсэн олон арван залуучуудыг шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хувь заяагаа холбох нөхцлийг бүрдүүлсэн байдаг.

2017 оны хуулийн зохицуулалтаар урамшууллын зохицуулалтгүй болж, энгийнээр ажиллаж байсан шийдвэр гүйцэтгэгчид цэргийн цол хэрэглэх болсноор он удаан жил ажилласан шийдвэр гүйцэтгэгч нарын ажилласан жилийг цэргийн ажилласан хугацаанд тооцох боломжгүй болсон нь шинэчлэн батлагдсан эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр төрийн албан хаагчийн эрх зүйн байдал дордож, хохирсон ба шийдвэр гүйцэтгэгчид олноороо ажлаас гарах нөхцлийг бий болгосон байна.

Тухайлбал ихэнх эмэгтэй шийдвэр гүйцэтгэгчдийн хувьд цэргийн алба хаах насны дээд хязгаарт дөхсөн, зарим нь хүрсэн, түүнчилэн ШШГТХуулийн /2017/ нэмэлт өөрчлөлтөөр шийдвэр гүйцэтгэгчийн ажилласан нэг жилийг 1.2 жилд тооцох болсноор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан жилийн хугацаа нь 20-с дээш жил болж байгаа ч Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулинд заасан журмын дагуу тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх боломжгүй, нөгөөтэйгүүр уг хуулиар /иргэний байгууллагад/ энгийнээр нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан нэг жилийг зургаан сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцож цэргийн албан хаагчийн

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.//Төрийн мэдээлэл. 2002 он

тэтгэвэр тогтоохоор заасан эрх зүйн зохицуулалтууд нь шийдвэр гүйцэтгэгч нарт хохиролтой байна.

3. *“Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” санал асуулгын талаар:*

Шийдвэр гүйцэтгэгчдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй явуулахад урамшууллын эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор Монгол Улсын 21 аймаг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны 176 буюу нийт шийдвэр гүйцэтгэгчдийн 72.1 хувийг **“Урамшууллын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох”** судалгаанд⁵ хамруулж үзэв.

Судалгаанд оролцсон нийт шийдвэр гүйцэтгэгчдийн 39 хувь 1-3 жил, 12 хувь нь 3-5 жил, 25 хувь нь 5-10 жил, 24 хувь нь 10-аас дээш жил ажилласан байх ба 64 хувь нь урамшуулалын эрх зүйн зохицуулалттай байх үед ажиллаж байжээ.

✓ Урамшуулал таны ажлын бүтээмжинд хэр их нөлөө үзүүлж байсан бэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 59 хувь нь маш их нөлөөтэй байсан, 33 хувь нь их нөлөөтэй байсан, 6 хувь нь дунд зэрэг, 2 хувь нь бага;

✓ Цэргийн цол хэрэглэх болсноор санхүүгийн байдалд өөрчлөлт орсон эсэх гэсэн асуултад санал асуулгад оролцогчдын 40 хувь нь орлого багассан, 24 хувь нь өөрчлөлт гараагүй, 21 хувь нь орлого эрс багассан, 15 хувь нь орлого өссөн;

✓ Ажилдаа сэтгэл хангалуун байдаг эсэх гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 37 хувь нь боломжийн ажил олдвол ажлаа өөрчилнө, 34 хувь нь сэтгэл хангалуун, 24 хувь нь сэтгэл хангалуун бус, 5 хувь нь ажлаа өөрчлөхөөр шийдсэн;

✓ Ажилдаа сэтгэл хангалуун бус байгаагийн шалтгаанаа 35 хувь нь ажлын ачаалал их байна, 28 хувь нь цалин бага, 16 хувь нь удирдах ажилтнаас ирж буй дарамт их, 16 хувь нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талуудаас ирж буй дарамт, шаардлага их гэж хариулсан байна.

✓ Ажил үүргээ гүйцэтгэж байх үед шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талууд болон бусад этгээдээс шан харамж амлах, өгөх тохиолдол хэр их гардаг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 60 хувь нь огт гардаггүй, 30 хувь нь заримдаа гардаг, 6 хувь нь ихэвчлэн гардаг, 4 хувь нь байнга гардаг;

✓ Таныг ажлаа үр дүнтэйгээр хийж гүйцэтгэхэд юу? шаардлагатай гэж үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 33 хувь нь албадлагын арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй, 31 хувь нь хууль зүй, нийгмийн баталгааг сайжруулах хэрэгтэй, 21 хувь нь ажлын ачааллыг багасгах, 15 хувь нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай

⁵ Ю.Оюунаа, М.Хажидмаа. “Урамшууллын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа” (2020).

гүйцэтгэх, ажиллах нөхцөл бололцоогоор бүх талаар хангасан бүтэц, тогтолцоог бий болгох;

✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай юу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдийн 95 хувь нь шаардлагатай байна гэж үзсэн бөгөөд цэргийн цол хэрэглэхийн зэрэгцээ урамшуулал авдаг болох саналтайгаа илэрхийлсэн юм.

4. *Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын талаар:*

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд халдах, эрсдлийг судлах зорилгоор улсын хэмжээнд үүрэг гүйцэтгэж байгаа 188 шийдвэр гүйцэтгэгчийг хамруулан судалгаа хийлээ.

Судалгаанд оролцогчдын 5.4 хувь нь өдөр тутамд халдлагад өртдөг, 91.3 хувь нь зарим тохиолдолд халдлагад өртдөг, 3.2 хувь нь халдлагад өртдөггүй гэж хариулсан байна.

Халдлага үйлдэж буй этгээдүүдийн 89.1 хувь нь хэл амаар доромжлох, гүтгэх, 18.9 хувь нь хараал хэлдэг байна. Халдлагын үйлдэхдээ 24.3 хувь нь тээврийн хэрэгслийг гэмтээх /дугуй хагалах гэх мэт/ 55.1 хувь нь биед хөнгөн гэмтэл учруулах, 2.7 хувь нь биед хүндэвтэр гэмтэл учруулах зэрэг үйлдлийг гаргасан байна.

Гэмт халдлага, зөрчилд өртсөн үедээ ямар арга хэмжээ авсан талаарх асуулгад шийдвэр гүйцэтгэгчдийн 48.6 хувь нь ажиллагааг амжилттай дуусгаад чимээгүй өнгөрсөн, 16.7 хувь нь ахлах гүйцэтгэгчээс тусламж хүссэн, 4.6 хувь нь Цагдаагийн байгууллагад хандсан гэж хариулсан.

Эрх бүхий байгууллагаас халдлага үйлдсэн этгээдийн 20.3 хувьд нь зөрчлийн болон эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн бол 79.7 хувьд ямар нэгэн хариуцлага хүлээлгээгүй байна⁶.

Шийдвэр гүйцэтгэгч албан үүргээ гүйцэтгэх явцдаа өдөр тутамдаа бусдын эсэргүүцэлтэй тулгарч улмаар хэл амаар доромжлуулах, халдлагад өртөх явдал хэвийн үзэгдэл болсон байгаа юм.

Түүнчилэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэндэд аюул учирах үед энгийн их, дээд сургуулийг эрх зүйчээр төгссөн шийдвэр гүйцэтгэгчид нь албаны харилцаа, биеэ хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэх чадвар дутмаг байдгаас аюулд өртөх эрсдэл өндөр байдаг байна.

Учир нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 211 дүгээр тушаалаар “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам” батлагдаж тухайн журмаар энгийн хууль зүйн их, дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн төгсөгчид

⁶ Ж.Нандинтуул “Шийдвэр гүйцэтгэгчин аюулгүй байдал, түүний мэргэжлийн хариуцлагын зарим асуудал” илтгэл.2020 он

сонгон шалгаруулалтанд оролцох, шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон ажиллах боломжийг бүрдүүлсэн⁷.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулж, зөвхөн мэдлэг сорих шалгалтын хүрээнд боловсон хүчнээ сонгож авч дараа нь тухайн мэргэжилтэндээ цэргийн хэргийн мэдлэгийг олгох, тэвчээр хатуужилд сургах гээд цаг хугацаа зарсан олон ажлыг хэрэгжүүлдэг ч төдийлөн үр дүнтэй байдаггүй байна⁸.

2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шийдвэр гүйцэтгэгч нь цэргийн цол хэрэглэхээр хуульчилсан бөгөөд уг хуулинд “Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, дээд боловсролтой, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна” гэж заасан⁹.

Дээрх шаардлага нь шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах боловсон хүчин нь цэргийн хэргийн эрдэмд суралцсан, биеийн болон сэтгэлийн тэвчээр, хатуужлийг эзэмшсэн, ажлын ачаалал даах чадвартай, шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбар эрх зүйн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн байх шаардлагатайг харуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Шийдвэр гүйцэтгэх албаны сургуулиас дээрх шаардлагыг хангасан боловсон хүчнийг ШШГЕГ-ын захиалгаар бэлддэг хэдий ч улсын хэмжээнд нийт ажиллаж байгаа шийдвэр гүйцэтгэгчдийн 29,0 хувийг л тус сургуулийн төгсөгчид эзэлдэг байна.

Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчдийнхээ амь бие, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдалд анхааран зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дүгнэлт

Төрөөс шүүхийн шийдвэрийг бодит биелэлтийг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг томоохон ажил нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан явдал юм. Хууль хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч шүүхийн

⁷ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 211 дүгээр тушаал

⁸ Ю.Оюунаа “Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах нь” илтгэл.”Шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл”, 2020 он

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.//Төрийн мэдээлэл. 2017 он

шийдвэрийн бодит биелэлт төдийлөн нэмэгдэхгүй, иргэд байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байгаа нь уг байгууллагаас гаргасан сүүлийн 3 жилийн статистик мэдээний үзүүлэлт, иргэдийн гаргах өргөдөл, гомдлыг тоо буурахгүй байгаагаас харж болно.

Шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль, эрх зүйн зохицуулалт, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн эрх зүйн ухамсар, соёл гэх мэт олон хүчин зүйл нөлөөтэй хэдий ч хамгийн гол нь шийдвэр гүйцэтгэгчийн хичээл зүтгэлээр шүүхийн шийдвэр биелэлээ олж хүний хөндөгдсөн эрхийг сэргээх үндэслэлийг бий болгодог.

Нийгэм эдийн засгийн харилцаа өргөжин тэлэхийн хэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ тэлж, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүн, биелүүлэх шийдвэрийн төрөл нэмэгдэж байгаа өнөө үед шүүхийн шийдвэрийг шуурхай, үр дүнтэй гүйцэтгэх нь шийдвэр гүйцэтгэгчээс ихээхэн ур чадвар, хичээл зүтгэл, тэвчээр хатуужлыг шаардсаар байна.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь хууль, журмаар далайлган хийчихдэг ажил биш юм. Шүүхийн шийдвэрийн төрөл, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчид харилцан адилгүй байдгаас шалтгаалан тухайн гүйцэтгэх баримт бичигт хийгдэх ажил, хэрэглэх тактик нь өөр өөр байх ба шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авахаас хааж дуусгавар болгох хугацааны туршид үүссэн бэрхшээл бүрийг даван туулж ажлыг үр шимээ үздэг.

Иймээс шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн ажилдаа хандах хандлагыг нэмэгдүүлэхэд тэдэнд тулгамдаж буй асуудлыг судалж тогтоон шийдвэрлэх шаардлагатай байна.

Шийдвэр гүйцэтгэгч нарын дунд тулгамдаж буй асуудалд хийсэн судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг нормативийг тогтоохдоо харьяалах нутаг дэвсгэрийг бүсчилсэн байдлаар тогтоосон. Гэвч бодит байдал дээр шийдвэр гүйцэтгэгч бүрийн ажлын ачаалал нь харьяалах тойргийн газар нутгийн хүн амын төвлөрлөөс шалтгаалаад зарим тойрогт жишиг нормативт заасан тооноос бага, их зэргээр харилцан адилгүй байна.

Улсын хэмжээнд ажлын ачааллаараа тэргүүлдэг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчдийн нэг өдрийн

ажлын зураг авалтыг хийж, өдөр тутамдаа тогтмол хийдэг ажлуудын цагийг нэгтгэн дүгнэхэд 13 цаг 50 минут болж байгаа юм .

Ажлын зураг авалтанд багтсан ажлаас гадна төлбөр төлөгч, бусад этгээдийн хүч түрсэн эсэргүүцэл, төлбөрөөс зайлсхийсэн үйлдэлтэй тулгарч, ажлын байранд байнга сууж ажиллахаас илүү төлбөр төлөгчдийн араас хөөцөлдөх, төлбөр төлөгч, тэдний хөрөнгийн мэдээлэл, нотлох баримтыг цуглуулах, өөрийн гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд төлөөлөн оролцох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дуудсан цагт очиж тайлбар, мэдүүлэг өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх г.м. ажлыг хийж гүйцэтгэдэг байна.

Шийдвэр гүйцэтгэгч бүр Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд заасан ердийн өдрийн ажлын цагаас даруй 2 дахин их цагаар ажилладаг болох нь судалгааны явцад тогтоогдож байна.

Шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачааллыг бүсчилсэн байдлаар тогтоосон нь ажлын ачааллыг үүсгэж улмаар шийдвэр гүйцэтгэгчийн ажлын бүтээмжийг муутган шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үр дүн гарахгүй байх нөхцлийг үүсгэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002/ хуулиар шийдвэр гүйцэтгэгчийг эрх зүйн дээд боловсролтой байхаар, шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулал цалинтай байхаар хуульчилж өгсөн нь эрх зүйн дээд боловсрол эзэмшсэн олон арван залуучуудыг шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хувь заяагаа холбох нөхцлийг бүрдүүлсэн байдаг.

2017 оны хуулийн зохицуулалтаар урамшууллын зохицуулалтгүй болж, энгийнээр ажиллаж байсан шийдвэр гүйцэтгэгчид цэргийн цол хэрэглэх болсноор он удаан жил ажилласан шийдвэр гүйцэтгэгч нарын ажилласан жилийг цэргийн ажилласан хугацаанд тооцох боломжгүй болсон нь шинэчлэн батлагдсан эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр төрийн албан хаагчийн эрх зүйн байдал дордож, хохирсон ба шийдвэр гүйцэтгэгчид олноороо ажлаас гарах нөхцлийг бий болгосон байна.

Учир нь өмнөх хуулийн үйлчлэлийн үед шийдвэр гүйцэтгэгчээр томилогдсон олон арван албан хаагчдын ихэнх нь цэргийн алба хаах насны дээд хязгаарт дөхсөн, зарим нь хүрсэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан хугацаа нь хэдий нь цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгох хугацаанд хүрсэн ч тухайн боломжийг эдэлж чадахгүй,

хэрэв тэтгэвэр тогтоолгохоор бол энгийнээр нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан нэг жилийг зургаан сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцуулах буюу энгийн ажилласан хугацаанаас хасуулах болсон байна.

Хуулийн шинэчлэлийн үр нөлөөнөөс шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдал дордож хохирсон байх ба хууль зүй, нийгмийн баталгаа хангагдаагүй байдлаас албан үүргээ сэтгэл хангалуун бусаар гүйцэтгэж байгаа нь анхаарал хандуулах, шийдвэрлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2017 оны хууль хэрэгжиж эхэлснээс буюу 2018 оны 01 дүгээр сараас эхлэн шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгохгүй болсноор өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийт алба хаагчдын 20 гаруй хувь нь ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн байх бөгөөд ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр гүйцэтгэгчдийн 22 хувь нь тухайн ажлын байранд арваас дээш жил тасралтгүй ажилласан туршлагатай алба хаагчид байсан нь анхаарал татаж байна.

Шийдвэр гүйцэтгэгчдийн орлого эрс багассан ч ажлын ачаалал нь багасаагүй нь тэдний ажилдаа хандах хандлагын сулруулж улмаар боломжийн ажил олдвол ажлаа өөрчлөх хүсэлтэй байдаг. Түүнчилэн шийдвэр гүйцэтгэгч нь өдөр тутамдаа төлбөр төлөгч хүн, хуулийн этгээдийн өмч, хөрөнгө мөнгөтэй харьцаж, түүнийг шийдвэрлэх эрхтэй ажилладаг нь бусдаас шан харамж амлах, авлигад өртөх эрсдлийг ч үүсгэдэг байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд “урамшуулал” нь шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ур чадвар гарган үр дүнтэй гүйцэтгэх хөшүүрэг нь болж байсан бөгөөд шийдвэр гүйцэтгэгч ажлын байран дээрээ хөгжих, хууль хэрэглээний чадвар нэмэгдэн мэргэшиж байсныг, ажлын байрандаа тогтвортой ажиллах эдийн засгийн баталгаа болж байсныг гэрчилж байна.

Нөгөө талаас Монгол Улсад шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр жинхэнэ утгаараа заавал биелэгддэг байх, шийдвэр гүйцэтгэгч бусдын нөлөөнд автахгүй, хараат бус, ажилдаа сэтгэл хангалуун, тогтвор суурьшилтай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгчийн одоогийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр урамшууллын тогтолцоог сэргээн, шийдвэр гүйцэтгэгчийн хууль зүй, нийгэм, эдийн

засгийн баталгааг сайжруулах хэрэгцээ, шаардлага байгааг судалгаа харуулж байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэн батлагдан хэрэгжиж эхэлсэн хэдий ч шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай бус, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй явуулах нөхцөл хангагдаагүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг хангах, бусдаас хараат бус байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд хууль эрх зүйн хүрээнд томоохон өөрчлөлт хийх шаардлага үүсч байна.

Тухайлбал шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндийг шийдвэр гүйцэтгэгчээр томилогдсон өдрөөс нь заавал даатгах даатгал хамруулах асуудлыг шийдвэрлэх, энэ төрлийн даатгал хөгжсөн гадаад улс орнуудын сайн жишээг судалж нутагшуулах шаардлагатай.

Мөн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд ДХИС-ийн ШШГАС-ийн магадлан итгэмжлэгдсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй” хөтөлбөрийн хүрээнд дээрх мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн, ШШГТухай хуулинд заасан шийдвэр гүйцэтгэгчид тавигдах шаргуур шаардлагыг хангасан боловсон хүчнийг түлхүү томилох бодлогыг хэрэгжүүлэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарах хүндрэл багасах боломжтой юм.

Эсхүл шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төрлийг нэмж, бие бялдар болоод сэтгэхүйн хөгжил, түвшинээр шалгах шалгалтын төрлийг нэмэгдүүлэх, цаашлаад гардан тулаан, тусгай хэрэгсэл ашиглах сургалтанд тогтмол хамруулах болон шийдвэр гүйцэтгэгчдэд сэтгэл зүйн зөвлөгөө, тусалцааг тогтмол үзүүлж байх үйлчилгээг нэвтрүүлэх нь зүйтэй.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999).
3. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2002).
4. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017).

Хоёр. Эрдэм шинжилгээний илтгэл, судалгааны тайлан

1. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 211 дүгээр тушаал

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний нэгж байгууллагад алба хааж байгаа албан хаагчдын ажлын жишиг норматив (2017).
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны жилийн эцсийн мэдээ, судалгаа (2018, 2019, 2020)
4. Ю.Оюунаа “Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах нь” илтгэл (2020)
5. Ж.Нандинтуул “Шийдвэр гүйцэтгэгчин аюулгүй байдал, мэргэжлийн хариуцлагын зарим асуудал” илтгэл (2020)
6. Ю.Оюунаа, М.Хажидмаа. Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалалд хийсэн судалгаа (2020).
7. Ю.Оюунаа, М.Хажидмаа. Урамшууллын хэрэгцээ шаардлага тодорхойлох судалгаа (2020).
8. Б.Алтангэрэл. Шийдвэр гүйцэтгэлийн судалгааны тайлан (2020).

Гурав. Цахим хаяг

1. <https://www.legalinfo.mn/law/details/7475>